"МОНГОЛ УЛСЫГ 2021 - 2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ" -ИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

№	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ	Төсөв /сая төг/		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт	Үнэл-гээ /хувь/	Тайлбар
		Төсөв-лөсөн	Гүйцэт-гэл		Он	Түвшин	Он	Түвшин			
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Зорилго 4.Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.											
Зорилт 4.4.Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгааг эхлүүлэх											
1	Арга хэмжээ 4.4.1.Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын эдийн засгийн коридорыг хөгжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ	49.9 сая төгрөг	0 төгрөг	Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжилтэд нь ахиц гарсан төсөл, арга хэмжээний тоо.	2021	1 төсөл, арга хэмжээ	2025	6 төсөл, арга хэмжээ	“Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх гурван талын ажлын хэсгийн шинжээчдийн түвшний тавдугаар уулзалтыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, уулзалтад монголын талыг Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал Г.Өлзийсайхан, оросын талыг Эдийн засгийн хөгжлийн яамны Хоёр талын хамтын ажиллагааны хөгжлийн газрын захирал А.Ю.Дианов, хятадын талыг Хөгжил, шинэчлэлийн хорооны Бүс нутгийн нээлттэй хөгжлийн газрын дэд дарга Жан Мин нар тус тус ахлан оролцсон. Тус уулзалтаар Эдийн засгийн коридорын хөтөлбөрт тусгагдсан Төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх төслийн чухал баримт бичгүүд болох "Төмөр замын Төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийн ажлыг эхлүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл"-ийн төсөл болон түүний хавсралт "Төмөр замын төв коридорын техник, эдийн засгийн	100%	

									үндэслэлийн Ажлын төлөвлөгөө"-ний төслийг эцэслэн тохиролцсоныг харилцан баталгаажуулж, гарын үсэг зурах үйл ажиллагааг 2022 онд хэрэгжүүлэхээр тохиролцов. "Төмөр замын төв коридорын техник, эдийн засгийн үндэслэлийн Ажлын төлөвлөгөө"-г амжилттай хэрэгжүүлснээр Монгол Улсын төмөр замын төв коридорын нэвтрүүлэх чадамж нэмэгдэхийн зэрэгцээ цаашид цахилгаанжуулах боломж бүрдэнэ.		
	Арга хэмжээ 4.4.2.Гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ	0 төгрөг	0 төгрөг	Монгол Улс, Европын Холбоотой "Газар зүйн заалтын тухай хэлэлцээр" байгуулах яриа хэлэлцээг эхлүүлсэн эсэх.	2021	Монгол Улс, Европын Холбоо хоорон д "Газар зүйн заалтын тухай хэлэлцээр" байгулах бэлтгэл хангах Ажлын хэсгийг байгуулсан эсэх.	2025	Монгол Улс, Европын Холбоотой "Газар зүйн заалтын тухай хэлэлцээр" байгуулах яриа хэлэлцээг эхлүүлсэн байна.	1. Монгол Улс, Европын Холбоо хооронд "Газар зүйн заалтын тухай хэлэлцээр" байгуулах бэлтгэл ажлыг хангах, санал боловсруулах, хэлэлцээнд оролцох үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2021 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн А/179/А/44 дүгээр хамтарсан тушаалаар байгуулсан. Монгол Улс, Европын Холбоо хооронд "Газар зүйн заалтын тухай хэлэлцээр" байгуулах бэлтгэлийг хангах ажлын хүрээнд Европын Комиссын Техникийн туслалцаа, мэдээлэл солилцооны газрын цахим сургалтыг Оюуны өмчийн газар болон МҮХАҮТ-тай хамтран 2021 оны 11 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад нийт 45 хүн хамрагдсан.	100%	
2				1.БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр	2021	1.БНСУ-тай Эдийн засгийн	2025	1.БНСУ-тай Эдийн засгийн	1.Монгол Улс, БНСУ-ын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны ажлыг 2016 онд эхлүүлж, судалгааг 2017 онд	100%	

				байгуулах судалгааг шинэчилсэн эсэх. 2.Судалгаанд үндэслэн Монгол Улсын байр суурийг тодорхойлох ажлын явц, хувиар.		түншлэлийн хэлэлцээр байгуулах судалгааг шинэчилсэн байна. 2.0 хувь.		түншлэлийн хэлэлцээр байгуулах судалгааг шинэчилсэн байна. 2.100 хувь.	хийж гүйцэтгэсэн. 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр болсон Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны цахим уулзалтаар Монгол Улс, БНСУ-ын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааг шинэчлэхээр тохиролцсон. Монгол Улс, БНСУ-ын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах судалгааг шинэчлэх ажлыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлж, хоёр улсын эдийн засгийн харилцааны өнөөгийн байдал, хоёр талын худалдаанд хийсэн шинжилгээ, Монгол-Солонгосын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн эдийн засгийн үр нөлөө, Монгол Улс, БНСУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв зэрэг зөвлөмжүүдийг тус тус шинэчилсэн. Чингээд Монгол Улс, БНСУ-ын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааг 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдөр шинэчилж дуусгав. 2.Тайлагнах хугацаа болоогүй.		
3	Арга хэмжээ 4.4.3.Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх бэлтгэл ажлыг хангаж,	0 төгрөг	0 төгрөг	Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрт нэгдсэн эсэх.	2021	Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх	2025	Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх	Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрт нэгдэн орох үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдаар 2021 оны 5 дугаар сард батлуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авч, хэлэлцээрийг соёрхон батлах тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг холбогдох баримт бичгийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2021 оны 8	100%	

	худалдааг хөнгөвчилнө					тухай ерөнхий хэлэлцээрт нэгдэн орох үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдаар батлуулсан байна.		тухай ерөнхий хэлэлцээрт нэгдэн орсон байна.	дугаар сарын 31-ний өдөр 07/3758 тоот албан бичгээр хүргүүлэв.		
Зорилго 5.Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.											
Зорилт 5.5.Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх											
4	Арга хэмжээ 5.5.3. Хилийн чанадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, улс төрийн	990 сая төгрөг /цахим виз/	682 сая төгрөг /цахим виз/	1.Хилийн чанадад зорчсон Монгол Улсын иргэдийн бүртгэлийг төгөлдөржүүлэх, консулын үйлчилгээг цахимжуулах	2021	1. 20% 2. 1	2025	1. 100% 2.1	1. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хилийн чанадад байгаа Монгол Улсын 25880 иргэн www.citizen.gov.mn цахим хуудсаар сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн байна. Мөн Засгийн газраас 2021 оны 5 дугаар сард иргэн бүрт олгосон 300.000 төгрөгийн тусламжийг авахаар Ebarimt цахим системд хилийн чанадаас	1.100% 2.100%	Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 9 дэх заалтын

	болон бусад эрхээ хэрэгжүүлэх, монгол хүүхэд эх хэлээрээ сурч боловсрох боломжийг бий болгосон эрх зүйн орчныг бүрдүүлсэн байх			хүрээнд хэрэгжүүлсэн ажлын явц, хувиар. 2.Эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр өгсөн саналын тоо.					88.857 иргэн бүртгүүлж, тусламж хүлээн авсан. Консулын үйлчилгээг цахимжуулах хүрээнд Монгол Улсын цахим визийн системийг 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс нэвтрүүлж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гадаадын 94 иргэн цахимаар виз мэдүүлснээс 88 иргэнд зохих ангиллын визийг олгосон. Мөн хилийн чанадад байгаа монгол иргэдийн түгээмэл авдаг 40 төрлийн лавлагаа, тодорхойлолт авах үйлчилгээний холбоосыг төрийн үйлчилгээний "E-Mongolia" порталд байршуулж, "Коронавируст халдварын Ковид-19" вирусын вакцинд хамрагдсаныг нотлох гэрчилгээг "E-Mongolia" порталаас олгож эхэлсэн болно. 2. БШУЯ-наас 1а/6192 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийн 2 заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 11/5666 дугаар албан бичгээр БШУЯ-нд хүргүүлэв.		дагуу монгол хүүхэд эх хэлээрээ сурч боловсрох эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал Боловсрол, шинжлэх ухааны яамны чиг үүрэг хамааралтай болно.